



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 34

Мандалговь

**Ч.Өлзийжаргалыг Нийгмийн даатгалын хэлтсийн  
Сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд  
нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Чулуу овогтой Өлзийжаргал 61.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Ч.Өлзийжаргалын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

**ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ**



**Нийгмийн даатгалын хэлтсийн Сан хариуцсан  
мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлсэн  
Ч.Өлзийжаргалын тухай дүгнэлт**

1. Ч.Өлзийжаргал нь 1976 онд Дундговь аймгийн Өлзийт суманд төрсөн. 46 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2008-2011 онд Монгол Улсын Их сургуулийг нягтлан бодогч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2012-2016 онд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Өлзийт сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, 2016-2018 онд ХХҮГ-ын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, 2018-2020 онд тус байгууллагад халамжийн олголт хариуцсан мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан.
4. Ч.Өлзийжаргалын төрийн албанд ажилласан дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Нийгмийн даатгалын хэлтсийн Сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

